

МОНГОЛ УЛС ДАХЬ АРДЧИЛЛЫН ХӨГЖИЛД ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Эрхэм хүндэт хурал даргалагч аа,
Үндсэн хуулийн шүүхийн ерөнхийлөгч, дарга, тэргүүн шүүгч нар аа,
Хүндэт хатагтай, ноёд оо,

Юуны өмнө энэхүү Олон Улсын бага хурлыг зохион байгуулж буй Тайваны Үндсэн хуулийн шүүх, хуралд оролцож илтгэл тавьж буй шүүгчид, зочид төлөөлөгчид Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн өмнөөс халуун дотно мэндчилгээ хүргэе.

Энэхүү бага хурал өмнөх хурлуудын адил үр өгөөжтэй, амжилттай болно гэдэгтэй итгэлтэй байгаагаа илэрхийлэхэд таатай байна.

Миний бие энэхүү хуралд тавих илтгэлээ Монгол Улс дахь ардчиллын хөгжилд Үндсэн хуулийн цэцийн гүйцэтгэж буй үүргийн талаар танилцуулахаар бэлтгэсэн юм.

Нэг. Монгол Улс ардчилалд шилжихээс өмнө болон шилжих үеийн улс төр, эрх зүйн нөхцөл байдлын талаар

1. 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улсын анхдугаар Их Хурал БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийг санал нэгтэй баталж, “Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс хэмээж Улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгүүлэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино”¹ гэж тунхаглав. Ийнхүү Монгол Улс 1924 онд анхдугаар Үндсэн хуулиа баталснаас хойш 1940, 1960, 1992 онуудад гурван удаа шинээр Үндсэн хуулиа баталсан түүхтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийг агуулгын хувьд социалист, ардчилсан гэх хоёр хэв маягт хуваана. 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд нь социалист хэв маягт хамаарах бол 1992 оны Үндсэн хууль ардчилсан хэв шинжтэйд тооцогддог. 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд нь социализмын үзэл баримтлалыг эдийн засгийн болон улс төрийн чиг баримжаа болгосон учраас ийнхүү социалист хэв маягт багтаж буй юм².

Социалист эрх зүйн тогтолцооны гол үзэл санаа нь нэг намыг улс төрийн тогтолцооны гол цөм болгож, түүний үзэл суртал, үйл хэргийг хамгаалан бэхжүүлж, ажилчин анги, түүний тэргүүний хэсэг нийгмийг удирдаж, хяналт тавьж, эрх зүйн хэм

¹ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль, 1924 он. 1 дүгээр зүйл.

² Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ, 2006. 12-13 дахь тал.

хэмжээ тогтоох үйл явц намын хяналтад байж, түүний бодлого, үзэл суртал, хөтөлбөр нь эрх зүйн үндсэн эх сурвалж болж байдаг оршино³.

Дээр дурдсан социалист Үндсэн хуулиуд нь өөр хоорондоо зарим зүйлээрээ ялгаатай боловч нам төвтэй хөгжлийн зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийн шинжтэй, үзэл сурталч, ангич байр сууринаас хандаж, хүн амаа анги давхаргаар ялгаварлаж, эрх чөлөөг нь хагасалж, төрийн хатуу төвлөрсөн удирдлага, нэг намын ноёрхол бүхий улс төрийн дэглэм тогтоож байснаараа адил төстэй ажээ.

2. Ингэхдээ марксист онол, тэр дундаа формацийн онолыг социализмын үзэл санааны гол үндэс болгосон байдаг.

Ийм үзэл санаа, эрх зүй, соёл Монголын социалист эрх зүйн тогтолцооны цөм болсоор 1990-ээд он хүртэл үргэлжилсэн юм. Учир нь Монгол Улсад ардчилсан үйл явц өрнөхөд 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль” ихээхэн ач холбогдолтой байдаг. Энэ хуулиар 1960 оны Үндсэн хуулийг хүчингүй болгоогүй мөртлөө ардчилалд шилжихэд шаардлагатай нөхцөлүүдийг Үндсэн хуулийн төвшинд тунхаглаж чадсан юм.

Монгол Улс социалист Үндсэн хуулийг дагаж мөрдсөн 70 гаруй жилийн хугацаанд тусгаар байдлаа бэхжүүлж, нийгэм соёлын амьдралын хувьд хөгжлийн шинэ шатанд гарсан боловч нөгөө талаар тоталитар дэглэмд оршиж нийгэм, эдийн засгийн байгууллын буюу формацын онол тэргүүтнийг баримталсны улмаас хүн төрөлхтний хөгжлийн жам ёсноос гажиж улс төр, эдийн засгийн талаар дэлхийн хөгжлөөс хоцорч, улмаар зарим талаараа мухардалд орсныг судлаачид тэмдэглэсэн нь бий⁴.

Үүнийг тухайн үеийн ЗХУ-ын коммунист намын улс төрийн дүгнэлтэд “Хүчирхэг машины том гэгч нь эрчлүүр эргээд байдаг, гэтэл ажил гүйцэтгэдэг эд ангийг хөдөлгөх учиртай дамжуулагч нь хий эргээд, өөрөөр хэлбэл хүч дамжуулагч тууз нь хэт суларсан, тийм тун хачин байдал бий болов”⁵ гэж тодорхойлсон байдаг.

Би үүнийг энд дурьдаж байгаа нь санамсаргүй хэрэг биш юм. Учир нь Монгол Улсын тухайн үеийн улс төрийн нөхцөл байдалд ЗХУ маш их нөлөөтэй байсантай холбоотой.

Иймд тухайн үеийн ЗХУ-д өрнөсөн “перестройка” буюу “өөрчлөн байгуулалт”-ийн үзэл санаа, улмаар түүнд үндэслэн социалист системийг задралд оруулсан том үйл явц Монголын ардчиллын хөгжилд улс төрийн томоохон нөлөө үзүүлсэн гэж дүгнэх боломжтой.

3. Монгол Улсын дотоодод 1990 онд ардчилсан хөдөлгөөн бий болж, жагсаал, цуглаан нь өлсгөлөн суулт болон үргэлжилсэн. Ингэснээр тэд тухайн үеийн төрийн удирдлагуудтай шинэ ардчилсан Үндсэн хуулийг батлах талаар зөвшилцөлд хүрч чадсан

³ Н.Лүндэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Уб., 2002. 237 дахь тал.

⁴ Чимид Б. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). Уб., 2006. 27 дахь тал.

⁵ Горбачев М.С. Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ манай оронд ба дэлхий дахинд. Уб., 1988. 15 дахь тал.

нь Монголын нийгмийн ардчилсан шилжилтийн томоохон ололт бөгөөд социалист нийгмээс ардчилалд тайван замаар шилжсэн үйл явц нь дэлхийд гайхагддаг юм.

Энэ талаасаа монголын шилжилтийн үйл явц нь шинээр бий болсон сөрөг хүчнийхний хүчтэй шахалтаар хуучин эрх баригчид буулт хийснээр ардчилал тогтож эхэлсэн (transplacement) хэв маягт хамаардаг юм.

Үүний үр дүнд 1990 оны дунд үеэс нэг намын ноёрхлыг халж, ардчилсан шинэтгэлийн хууль зүйн үндсийг 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль”-аар тавьж, улмаар 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улс түүхэн дөрөв дэх Үндсэн хуулиа баталсан билээ.

Ингэснээр хүний жам ёсны эрхийг тэргүүн зэрэгт тавьж, улс төрийн ардчилал, олон ургалч үзэл, эдийн засгийн чөлөөт байдал, төрийн эрх мэдэл хуваарилах, нутгийн өөрөө удирдах ёс, хараат бус, шударга, бие даасан шүүхийн тогтолцоо, Үндсэн хуулийн хяналтыг анх удаа баталгаажуулсан юм.

Хоёр. 1992 оны Үндсэн хуулиар ардчиллын үзэл санааг тунхаглан мөрдүүлсэн нь

1. Үндсэн хууль бол аливаа орны гол хууль төдийгүй улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч хууль мөн. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн хэрэгжилт сайн байж гэмээнэ тухайн улсад нийгмийн тогтвортой байдлын үндэс бүрдэнэ. Ардчилсан үзэл санаа бол эдүгээгийн хөгжингүй болон хөгжиж буй ихэнхи улс орны баримтлах гол үзэл санаа, хүний эрх, эрх чөлөөний үндсэн баталгаа, хөгжлийн үндсэн чиг хандлага болон нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн байна.

2. Ардчилсан ёсны зарчмыг манай улсын хууль зүйн салбарын эрдэмтэн судлаачид дараах байдлаар тайлбарласан байдаг: “Тус зарчим нь ард түмний засаглах бүрэн эрх гэсэн утгыг илэрхийлэн ард түмний засаглалыг зохион байгуулах үндсэн арга зам болдог. Ардчилсан зарчимд засаглах эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагыг ард түмэн сонгох, үйл ажиллагаанд нь оролцох, хяналт тавих, олон намын тогтолцоо, олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрөх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хангах, хэвлэлийн эрх чөлөөг хүндэтгэх, олны санаа бодол, гаргасан шийдвэрт тулгуур ач холбогдол өгөх зэрэг олон элементээр хэлбэршин илэрдэг баялаг агуулгатай юм⁶. Ардчилсан ёс нь төрийн аливаа үйл ажиллагааг зохих шат болон түвшинд нийтээрээ хэлэлцэж, эцсийн эцэст олонхийн саналаар шийдвэрлэж тэр шийдвэрээ бүгдээрээ хүндэтгэн биелүүлдэг өндөр соёлтой хатуу хариуцлага мөн. Иймд ардчилсан ёс гэдэг бол аль нэг хүний буюу хэсэг бүлэг этгээдийн ард түмний нэр барьж дур зоргоороо авирлах эмх журамгүй явдал огт биш, ард түмний олонхийн санал зоригийг хэрэгжүүлэх нарийн тогтсон дэг журам юм”⁷ гэжээ.

⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Уб, 2009. 14-15 дахь тал.

⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Уб, 2000. 27 дахь тал.

Нөгөө талаас ардчилсан ёс нь хүний нийгмийн идэвх, байр суурь, мөн чанарыг илтгэн харуулж, бие хүн болгодог онцгой ойлголт болно. Үүний гол илрэл нь хүний улс төрийн эрх, эрх чөлөөгөөр дамжин илэрч байдаг. Тодруулбал, сонгох, сонгогдох, мэдээлэл хайх, төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх зэрэг эрх, эрх чөлөөг энд дурдаж болно.

Монгол Улсын Үндсэн хуульд дээрх эрхүүдийг баталгаажуулан Арван зургадугаар зүйлийн 9-д “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, 10-т “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно...”, 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй...”, 12-т “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй...”, 13-т халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...;16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;” хэмээн хуульчилж ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлсэн.

Шинэ Үндсэн хууль XX зууны сүүлийн хагаст дэлхий дахинд өрнөсөн их өөрчлөлтийн үзэл санааг угтан тосч, хүн төрөлхтөний түгээмэл үнэт зүйлсийн хэмжээнд нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн либераль ардчиллын суурь үнэлэмжүүдийг эх орноо ардчилсан замаар хөгжүүлэх үзэл баримтлал болгон баталгаажуулснаараа орчин үеийн эрх оронч үзлийн шинэ агуулга, монголын ард түмний ардчилсан эрхэмнэлийн (идеал) дээд үнэлэмж болж чадсан юм.

Гэвч өөрчлөлт, шинэчлэл үргэлжилж, нийгэм, улс орон эрчимтэй хөгжиж буйг тусган Үндсэн хуулийн хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийж, түүний үзэл баримтлал, эрх зүйн чадамжийг бүрэн дүүрэн нээн ашиглах, зарим үндэслэл, заалтыг нь боловсронгуй болгох ёстой гэх үүднээс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудал улс төрийн хүрээнээс байнга гардаг ч энэ нь ардчилсан Үндсэн хуулийн үндсэн бүтцийг хөндөхгүй байх хуультай⁸.

Энэ бол Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэгч Үндсэн хуулийн цэцийн хувьд анхаарал татсан асуудал мөн.

⁸ Д.Одбаяр. Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол //Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (онол, арга зүй, хэрэгжилт). УБ, 2017. 103-116 дахь тал.

Гурав. Монголын ардчиллыг хамгаалахад Монгол Улсын Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэж буй үүрэг

1. Ардчилсан үзэл санааны хэрэгжилт нь Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоон баталснаар аяндаа хангагдана гэсэн үг биш бөгөөд түүнийг хамгаалах механизм заавал шаардлагатай байдаг. Ийм механизмын дотоодын эрх зүй дэх хамгийн дээд хэлбэр бол Үндсэн хуулийн шүүх юм.

Монгол Улсын Үндсэн хуулиар ардчиллын үнэт зүйлс, иргэдийн үндсэн эрхийг хамгаалах үүднээс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг Үндсэн хуулийн хүрээнд явуулах, тэдгээрийн эрх хэмжээг түүнд нийцүүлж хязгаарлахын тулд Үндсэн хуулийн цэцийг бий болгосон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага мөн” хэмээн заасан. Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргээ энэ хуульд заасан маргааны талаар дүгнэлт гаргах, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргааныг магадлан шийдвэрлэх замаар хэрэгжүүлнэ” гэсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд дээд хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага болохын хувьд байгуулагдсан цагаасаа эхлэн Монголын ард түмний хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгыг хамгаалан баталгаажуулж, Үндсэн хуулиар баталгаажуулсан ардчилсан ёсны зарчим, хүний эрхийг хамгаалж, Үндсэн хуульд дээд хяналт тавьж энэ талаарх хэм хэмжээний зөрчлийг таслан зогсоож ирсэн.

Тухайлбал, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлсон Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг⁹тэй холбоотой 70 орчим шийдвэрийг гаргаснаас 50 хувь нь ардчилсан ёстой холбоотой байна. Эдгээр шийдвэрүүдийн агуулгыг судлан үзэхэд Үндсэн хуулийн зөрчлийг таслан зогсоосон 35 шийдвэр гарчээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс иргэний эрх, эрх чөлөөтэй холбоотой 110 орчим маргаан хянан шийдвэрлэснээс улс төрийн эрх, эрх чөлөөтэй холбоотой маргаан 40 орчим хувийг эзэлж байна. Үүний мөн 50 орчим хувьд нь Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэрийг манай Цэц гаргасан байна.

Дээр дурдсанаас гадна аливаа төрийн байгууллагын үйл ажиллагаа ардчилсан ёсны зарчимд нийцэх ёстойг тогтоосон 20 орчим шийдвэрийг Үндсэн хуулийн бусад зүйл заалттай холбоотойгоор гаргаж байсан судалгаа байна. Тухайлбал, аливаа шүүхийн үйл

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “**Ардчилсан ёс**, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” хэмээн заасан.

ажиллагаанд ардчилсан ёсны зарчим хангагдах ёстойг тогтоосон шийдвэрийг гаргаж байсан жишээ ч байдаг¹⁰.

2. Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс шийдвэрлэсэн зарим маргааны талаар товч танилцуулъя.

- Иргэдийн жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хамгаалсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар сарын 15-ны өдөр 01 дүгээр тогтоол гарсан юм. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн зохицуулалттай холбоотой маргааныг уг тогтоолоор эцэслэн шийдвэрлэсэн. Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалтын “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ.”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг “цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн хэсгүүд нь тайван замаар хуран цуглах хүүхдийн эрхийг хязгаарлаж, Монголд Улс 1990 онд нэгдэж орсон хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцын заалттай зөрчилдөж, улмаар Үндсэн хуулиар баталгаажсан хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийг болон Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх үүргийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц шийдвэрлэсэн.

- Ардчилсан ёсны нэг илрэл, иргэдээс төрийг удирдах хэрэгт оролцох хэлбэрийн нэг нь сонгууль юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц байгуулагдсан цагаасаа хойш Сонгуулийн тухай хуультай холбоотой 16 маргааныг хянан шийдвэрлэснээс цөөнгүй удаа Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэрийг гаргасан байдаг. Эдгээрээс нэгэн жишээг дурдъя.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг 2005 онд шинэчлэн найруулж батлахдаа тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3-т уг сонгуульд нэр дэвшигчид “ялгүй байх” гэсэн шаардлагыг нэмж оруулсан юм. Энэхүү “ялгүй байх” гэсэн ойлголт нь урьд огт ял шийтгүүлж байгаагүй гэсэн агуулгыг илэрхийлж байсан бөгөөд улмаар Улсын дээд шүүх мөн энэ утгаар тогтоолоороо тайлбарлаж байв. Харин Үндсэн хуулийн цэц тус зохицуулалт нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан иргэдийн улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа **бүх насаар** нь хязгаарлаад зогсоогүй, тухайн хүнийг дэмжигчдийн сонгох эрхэд халдсан байна хэмээн үзэж 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдөр 06 дугаар дүгнэлт гаргаснаар сонгогч, нэр дэвшигчийн улс төрийн эрхийг сэргээж, Үндсэн хуулиар баталгаажсан ардчилсан ёсны зарчмыг хүний эрхийг зөрчих замаар хязгаарласныг таслан зогсоож бэхжүүлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц энэ мэтчилэн олон шийдвэрийг гаргаж нийгэмд жишиг болгон тогтоож ардчилсан ёсыг хамгаалан бэхжүүлэх, төлөвшүүлэх, хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж байна. Манай Үндсэн хуулийн цэцийн “Үндсэн хуулийг

¹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 1 дүгээр дүгнэлт

зөрчсөн” гэсэн шийдвэр нь тухайн зөрчлийг таслан зогсоогоод зогсохгүй дахин ижил, төстэй зөрчил гарахаас урьдчилан сэргийлж байдгаараа өндөр ач холбогдол үзүүлдэг юм.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс гаргасан шийдвэрүүд Үндсэн хууль зөрчсөн зөрчлийг таслан зогсоох онцгой ач холбогдолтой төдийгүй, ардчилсан хуульт ёсны төлөвшилд бодитой нөлөөгөө үзүүлсээр байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Эцэст нь дүгнэхэд Үндсэн хуулийг сахин хамгаалах, ардчиллын үнэт зүйлс, үзэл баримтлал, хүний эрхийг хамгаалахад Үндсэн хуулийн шүүхүүдийн үүрэг их юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц ч гэсэн ардчилсан Үндсэн хуулийн үнэт зүйлсийг хамгаалж, түүнийг хөгжлийг хангахад онцгой нөлөө үзүүлж байгааг цохон хэлэхэд таатай байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа!